

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл -ийн хувь						
					Эхний хагас жил								
Стратеги төлөвлөгөөний зорилго 1													
<b>Зорилт:1</b>													
Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх													
1.1	АРГА ХЭМЖЭЭ -1 “Албан хаагчдын ажлын байран дээрх сэтгэл зүйн эрүүл мэндийн хөтөлбөр” боловсруулж батлуулах	-	- Батлагдсан хөтөлбөрийн тоо	-	-1	Мерит төслийн зөвлөх Билл Гаугийн сургалтад хамрагдаж, сургалтаас гарсан санал, үр дүнд тулгуурлан “Албан хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэнд” хөтөлбөрийг боловсруулахаар аймгийн Хүний нөөцийн клубын гишүүдэд сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалт зохион байгуулан анхны ойлголт өгч, 2 удаагийн санал авч боловсруулсан. Мөн тус төслийг аймгийн цахим сайтад байршуулан иргэдийн төсөлтэй танилцах, санал өгөх нөхцөлийг бүрдүүллээ. Төслийг хэлэлцүүлэх явцад хөтөлбөр нэрээр батлуулбал улс орон нутгийн төсвөөс хөрөнгө гаргахад хүндрэлтэй болно гэсэн санал гарсны дагуу удирдамж, чиглэл гэсэн томьёололоор буюу “Ажлын байран дээрх сэтгэл зүйн эрүүл мэнд”-ийн талаар удирдамж, чиглэл батлах тухай гэсэн нэрээр 2022 оны 7 сарын 1-ний өдрийн А/298	100						

						дугаар аймгийн Засаг даргын захирамжаар батлагдлаа.	
1.2	АРГА ХЭМЖЭЭ -2 Төрийн албаны стандартыг хангасан “Хандлагаа өөрчилье-Хамтдаа хөгжие” хөдөлгөөн өрнүүлж, шилдэг сум, байгууллага, төрийн албан хаагчийг тодруулж урамшуулах	10 сая ОНТ	-Шилдэг сум -1 -Шилдэг байгууллага-1 -Шилдэг албан хаагч-3	-	-1	Байгууллагын соёлыг дээшлүүлэх, баримт бичгийн стандарт, эмх цэгцийг хангах, албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, төрийн үйлчилгээг иргэдэд таатай, сэтгэлд нийцсэн байдлаар хүргэх эерэг сэтгэлгээтэй баг, хамт олон болох зорилгоор “Хандлагаа өөрчилье -Хамтдаа хөгжье” аяны удирдамжийг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж дэмжүүлэн аймгийн Засаг даргын 2022 оны 7 сарын 1-ний өдрийн А/299 дугаар захирамжаар батлууллаа.	100
1.3	АРГА ХЭМЖЭЭ -4 Сум, байгууллагад шаардлагатай хууль тогтоомжоор сургалтууд зохион байгуулах	-	-Зохион байгуулагдсан сургалтын тоо	-3	-15	Сумдын ЗДТГ-ын дарга, нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоол болон төрийн жинхэнэ албан тушаалыг түр орлон гүйцэтгэх журмын талаар онлайнаар мэдээлэл өглөө. Мөн Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй, ёс зүйн дүрэм, хүлээх хариуцлагын талаар Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагч нийт 100 орчим хүнд сургалт хийлээ.	40
<b>Зорилт:2</b> Сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах, шалгалтын комисс бүрдүүлэх, ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах							
2.1	АРГА ХЭМЖЭЭ -1 Төрийн албаны тусгай шалгалт зарлуулах сул орон тооны захиалгыг тухай бүр хүлээн авах, баримт материалыг хянах	-	-Тусгай шалгалт зарлуулахаар ирүүлсэн албан тушаалын захиалгын тоо	-8	-12	Их газрын чулууны уулын хамгаалалтын захиргаа 2, Эрүүл мэндийн газар 6, Өлзийт сумын ЗДТГ 2, Адаацаг сумын ЗДТГ 2, Говь-Угтаал сумын ИТХ 1, ХХҮГ 2, МЭГ 2 нийт 2022 онд 2 сум, 4 байгууллагын 17 сул чөлөөтэй байгаа ажлын байрны захиалгыг хүлээн авч, холбогдох журмын дагуу хянаж бүртгэлээ. Дэс түшмэлийн 24, удирдах албан тушаалын 4, туслах албан тушаалын 37 нийт 65 ажлын байрны материалыг	100

						хянаж сонгон шалгаруулалт зарлалаа. Мөн дэс түшмэлийн 33 ажлын байрны захиалгын материалыг хянаж программд оруулан заруулахаар ТАЗ-д өгсөн байна.	
2.2	АРГА ХЭМЖЭЭ -2 Төрийн албаны ерөнхий шалгалтыг хууль тогтоомжийн дагуу бэлтгэл ажлыг ханганд зохион байгуулах	2 сая УТ	-Төрийн албаны ерөнхий шалгалт зохион байгуулсан тоо	-2 удаа	-2 удаа	Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах комиссыг ТАЗСЗ-ийн даргын тогтоолоор байгуулж бэлтгэл ажлын 24 заалт бүхий төлөвлөгөө гарган зохион байгууллаа. Тус аймагт 110 хүн шалгалтад бүртгүүлж, 99 шалгуулагч шалгалтад орж, 33 хүн тэнцэж төрийн жинхэнэ албан тушаалын нөөцөд бүртгэгдлээ.	100
2.3	АРГА ХЭМЖЭЭ -3 Төрийн албаны тусгай шалгалтыг хууль тогтоомжийн дагуу бэлтгэл ажлыг ханганд зохион байгуулах	-	-Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулсан тоо	-2 удаа	-2 удаа	Төрийн захиргааны удирдах албан тушаалын ахлах түшмэлийн 1, удирдах албан тушаалын дэс түшмэлийн 1, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэлийн 1, гүйцэтгэх албан тушаалын туслах түшмэлийн 1, төрийн үйлчилгээний төсвийн шууд захиргачийн 1, нийт 5 удаагийн төрийн албаны тусгай шалгалтыг бэлтгэл ажлыг ханганд зохион байгууллаа.	100
2.4	АРГА ХЭМЖЭЭ -4 Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах комиссыг тухай бүр байгуулж, шалгалтын баримт бичгийг хууль журмын дагуу тухай бүр бүрдүүлэх	-	-Шалгалт зохион байгуулах комисс томилсон тоо	-4 удаа	-4 удаа	Төрийн албаны тусгай шалгалтыг 5 удаа, төрийн албаны ерөнхий шалгалтыг 1 удаа зохион байгуулж шалгалт зохион байгуулах комиссыг тухай бүр байгуулж, шалгалтын өмнө бүртгүүлсэн оролцогчдын баримт бичгийн шалгалтыг комиссын гишүүдээр хууль журмын дагуу хийж, баталгаажуулж ажиллалаа. Шалгуулагчдаас ирүүлсэн ямар нэгэн гомдол санал байхгүй шалгалтууд зохион байгуулагдсан.	100
2.5	АРГА ХЭМЖЭЭ -5 Албан тушаалын сул орон тоонд зохих журмын дагуу нэр дэвшүүлэх, нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих	-	-Гаргасан тогтоолын тоо	-46	-46	5 удаагийн тусгай шалгалтын сонгон шалгаруулалтаар 3 иргэнийг тухайн албан тушаалд нэр дэвшүүлж томилууллаа. Нэр дэвшүүлсэн тогтоолын хэрэгжилтэд хяналт хийхэд Цэгцбилэг сургуулийн захирал, Нийгмийн даатгалын хэлтсийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшсэн 2 иргэнийг томилоогүй байсныг Сайнцагаан сумын Засаг дарга, ЗДТГ, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн	100

						удирдлагуудтай биечлэн болон утсаар ярж чиглэл өглөө. Цэгцбилэг сургуулийн захирлын материал АТГ-руу урьдчилан мэдүүлэг хянуулахаар явуулж баталгаажсан. Сан хариуцсан мэргэжилтний албан тушаал төрийн үйлчилгээний албан тушаал болж бүтцийн өөрчлөлт хийгдсэн байна. Үүнийг НДЕГ-т хүсэлт өгч шийдвэрлүүлэхээр боллоо.	
--	--	--	--	--	--	---	--

#### Зорилго:3

Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд аргачлал, удирдамжийн дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийх, үр дүнг мэдээллэх

3.1	АРГА ХЭМЖЭЭ-1 Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах, саналыг хянан танилцуулах	-	-Зэрэг дэв авсан албан хаагчийн тоо	-72	-75	Төрийн захиргааны жинхэнэ албан хаагч болж зэрэг дэвээ авах хүсэлт ирүүлсэн 74 албан хаагчдын материалыг ТАЗС3-ийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, аймгийн Засаг даргад зэрэг дэв олгуулахаар хүсэлт танилцуулгыг хүргүүлж шийдвэрлүүллээ.	100
3.2	АРГА ХЭМЖЭЭ-4 Төрийн албан хаагчийг холбогдох журамд заасны дагуу шагнаж урамшуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргэж шийдвэрлүүлэх	-	-Шагнагдсан албан хаагчийн тоо	-1	-3	“Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Ш.Төрбат, аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга Н.Эрдэнэ-Очир нарыг шагнуулах шийдвэрийг 4 дүгээр хуралдаанаар гаргаж Төрийн албаны зөвлөлд уламжлан шийдвэрлүүллээ.	100

#### Зорилго:4

Маргаан хянан шалгах газрын үүрэг даалгаварын дагуу асуудлыг шалгах, холбогдох баримт материалыг бүрдүүлэх, холбогдох этгээдээс тайлбар тодорхойлолт авах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах

4.1	АРГА ХЭМЖЭЭ-1 Маргаан хянан шалгах газрын үүрэг даалгаварын дагуу асуудлыг шалгах, холбогдох баримт материалыг бүрдүүлэх	-	-Хэрэгжилтийн хувиар	-70	-70	ТАЗ-ийн Маргаан хянах шалгалт газрын холбогдох албан хаагчдын чиглэл болгосны дагуу аймгийн ЗДТГ-ын дарга, ТЗУХ-ын дарга, СТСХ-ийн дарга, ХЭЗХ-ийн дарга, НДХ-ийн дарга, УБХ-ын дарга , Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын дарга нарт холбогдох гомдлын дагуу материалыудыг тухай бүр бүрдүүлж, асуудлыг шалган зохих тайлбарын хамт ТАЗ-д хүргүүллээ.	100
4.2	АРГА ХЭМЖЭЭ-2 Төрийн байгууллагуудын дэргэд” Ёс зүйн хороо”-г	-	-15 сум, -14 агентлаг	-15 сум, -14 агентлаг	-15 сум, -14 агентлаг	Төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл одоогийн байдлаар ТАЗС3-д мэдээллээ ирүүлснээр бол 15 байгууллага ёс зүйн зөвлөлтэй	70

	шинэчлэн байгуулах, сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх		-14 агентлаг		8 байгууллага ёс зүйн зөвлөл байгуулах шаардлагагүй гэж үзсэн байна. Харин 15 сум ёс зүйн зөвлөл байгуулан ажиллаж байна. Дээрх сум, байгууллагын ёс зүйн зөвлөлийг 2019 онд батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг үндэслэн байгуулсан байна. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын тухай хууль УИХ-аар хэлэлцэгдэж байгаатай холбогдуулан ёс зүйн зөвлөлийг шинэчлэх ажил хүлээгдэж байна.		
4.3	АРГА ХЭМЖЭЭ-4 Төрийн албан хаагчийн ёс зүйг сахиулах талаар төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулах, судалгаа хийх	-	-Сургалт, судалгааны тоо	-	-15 сум - 20 агентлаг	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй, ёс зүйн дүрэм, хүлээх хариуцлагын талаар Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагч нийт 100 орчим хүнд 4 удаагийн сургалт хийлээ.	40

### Зорилт:5

Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн хэвийн, тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

5.1	АРГА ХЭМЖЭЭ-1 Сум, агентлагийн тоо бүртгэл хөтлөх талаар арга зүйн удирдлагаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих	-	-Арга зүйн удирдлагаар хангасан тоо	-15 сум - 22 агентлаг	-15 сум - 22 агентлаг	Төрийн албаны хүний нөөцийн программ шинэчлэгдэж Сангийн яамны цалингийн нэгдсэн сан болон бусад зарим байгууллагын программтай холбогдож нэгдсэн тайлан, цалин татагддаг болсонтой холбогдуулан 15 сум, 22 агентлагийн хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдад мэдээлэл хүргэж, Луус, Өндөршил, Эрдэнэдалай сумдын цэцэрлэг, Говь-Угтаал, Дэрэн сумдын ЗДТГ, Сайнцагаан сумын Говийн ирээдүй сургууль, Хүмүүнлэг сургууль, СХЗХ, аймгийн ИТХ, Их газрын чулууны уулын хамгаалалтын захиргаа, Музей, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын хүний нөөцийн системд нэвтэрч програмд алдаа засаж өглөө. Мөн бүх сум, байгууллагын хүний нөөцийн системд хяналт хийж гарсан алдаа зөрчил болон мэдээллээ шинэчлээгүй газруудад 1 бүрчлэн утсаар ярьж заавар зөвлөмж өгсөн.	100

5.2	АРГА ХЭМЖЭЭ-3 Хүний нөөцийн системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах талаар холбогдох эрх бүхий албан хаагчтай нууцлалын гэрээ байгуулах, хяналт тавих	-	-Гэрээ байгуулсан тоо	-	-99 байгууллага	Хүний нөөцийн системийн өөрчлөлттэй холбоотой системд нэвтрэх эрхтэй албан хаагчдад тухай бүр мэдээлэл өгч ажиллалаа. Энэ хүрээнд нэвтрэх эрх бүхий албан хаагчидтай гэрээ байгуулахаар аймгийн ЗДТГ-аас сум, байгууллагад явсан хяналт шинжилгээ үнэлгээний багт холбогдох гэрээг өгч явууллаа. Гэрээний дагуу Говийн ирээдүй цогцолбор сургууль, Мандал сургууль, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, Дэлгэрхангай сумын ЗДТГ, Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг байгууллагууд баталгааны гэрээгээ ирүүллээ.	100
5.3	АРГА ХЭМЖЭЭ-4 "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль"-д заасны дагуу хүний нөөцийн ил тод байдлыг хангах хүрээний мэдээллийг аймгийн цахим хуудсаар сурталчлах	-	-Цахим хуудсаар сурталчилсан мэдээллийн тоо	-46	-100	Аймгийн цахим сайт dundgovi.gov.mn-д салбар зөвлөлийн шийдвэрийг 25, төрийн албаны сонгон шалгаруулалтын мэдээлэл 1, урсдаг зар 2, үйл ажиллагаатай холбоотой 14 мэдээлэл, 2021 оны үйл ажиллагааны тайлан з эргийг оруулж иргэдэд сурталчиллаа. Мөн Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөл пэйж хуудсыг хөтлөн 104 мэдээллийг иргэд олон нийтэд хүргэсэн байна. Төрийн албаны зөвлөлийн csc.gov.mn сайгад 65 удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын ажлын байрыг нийтэд байршуулж сурталчиллаа.	100

#### Зорилт-6

Салбар зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд салбар зөвлөлийн дарга, гишүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх

6.1	АРГА ХЭМЖЭЭ-1 Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулах, хуралдаанаар хэлэлцэн батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах	-	-Тайлангийн хэрэгжилтийн хувь	-90.8	-92.0	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 31 ажил арга хэмжээг төлөвлөн салбар зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн баталлаа. Салбар зөвлөлийн эхний хагас жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 92.1% байна	70
6.2	АРГА ХЭМЖЭЭ-2 Салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны	-	-Хуралдааны тоо	-7	-7	Салбар зөвлөлийн хуралдааныг эхний хагас жилд 3 удаа хуралдуулсан бөгөөд хурлаар нийт 11 асуудлыг хэлэлцүүлэн 100% батлууллаа. Хурлаас	100

	шийдвэр, тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах					гарсан шийдвэрийг албажуулан тэмдэглэл хөтөлж зохиж журмын дагуу материалыг бүрдүүлэн баримтжууллаа.	
6.3	АРГА ХЭМЖЭЭ-3 Төрийн алба, төрийн албан хаагчийн талаарх мэдээ, мэдээлэл, материал, тайлан, судалгаа хийх, судалгааг харьяалах байгууллагаас гаргуулж авах	-	Хэрэгжилтийн хувиар	-9	-9	Төрийн албатай холбоотой 6 төрлийн судалгаа, ТАЗ-ийн 2021 оны 411 дүгээр тогтоолын хэрэгжилт, Төрийн албананд шилжиж болон сэлгэн ажилласан судалгаа, байгууллагын бүтэц, орон тоо, төрийн албан хаагчийн цалингийн судалгаа, ТАЗ-ийн 7*4*10 вебинар сургалтад хамрагдагсдын зэрэг 11 судалгааг сум, байгууллагаар гаргуулан нэгтгэж холбогдох газарт хүргүүлсэн. Мөн төрийн захиргааны албананд томилгооны зөрчилтэй ажиллаж байгаа албан хаагчдын судалгааг хийлтээ.	100
6.4	АРГА ХЭМЖЭЭ-6 Салбар зөвлөлийн архив, албан хэрэг хөтлөлт, төрийн болон албаны нууцын асуудлыг эрхлэн гүйцэтгэх	-	Хэрэгжилтийн хувиар	-	-100	Салбар зөвлөлийн 2021 оны тогтоол шийдвэр, төлөвлөгөө тайлан, хуралдаан, зэрэг дэв, ирсэн бичиг, явсан бичиг, төрийн албаны сонгон шалгаруулалт зэрэг 8 хадгаламжийн нэгжийг бүрдүүлэн цэгцэллээ. Мөн салбар зөвлөлийн эрхлэх ажлын хүрээнд албаны нууцад хамаарах асуудлыг холбогдох мэдээллийг хамгаалан эрхлэн гүйцэтгэлээ.	100
6.5	АРГА ХЭМЖЭЭ-7 Салбар зөвлөлийн гишүүдийг мэргэжил арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах	-	-Сургалтын тоо	-	- 7 удаа	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэн холбоотой салбар зөвлөлийн ажиллах журам, салбар зөвлөлийн хуралдааны дэг, тусгай шалгалт зохион байгуулах журам, төрийн албаны ерөнхий шалгалт зохион байгуулах журмын талаар сургалт хийлтээ. Мөн тухай бүр арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.	100
6.6	АРГА ХЭМЖЭЭ-8 Иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл гомдлыг бүртгэл хяналтад авч тухай бүр шийдвэрлүүлэх	-	Хэрэгжилтийн хувиар	-100	-100	Салбар зөвлөлд 2022 оны эхний хагас жилд 76 албан ирснийг бүргэл хяналт авч хэрэгжилтийг 100% зохион байгууллаа. Хугацаа хоцорсон, хариутай бичиг байхгүй. Мөн салбар зөвлөлөөс 54 албан бичгийг төлөвлөн бүртгэж, холбогдох газруудад явуулсан байна.	100
6.7	АРГА ХЭМЖЭЭ-9	-	Хэрэгжилтийн хувиар	-100	-100	Салбар зөвлөлөөс гаргасан 43 тогтоолыг төслийн боловсруулан салбар зөвлөлийн даргаар баталгаажуулан холбогдох газруудад хүргүүллээ.	100

	Салбар зөвлөлд ирсэн, явсан бичгийг бүртгэл хяналтад авч хэрэгжилтийг хангах				Тогтоолын дагуу холбогдох газруудад хяналт хийж 2 тогтоолын биелэлтийг хангаагүй Сайнцагаан сумын Засаг дарга, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт хууль, журмын талаар зөвлөмж чиглэл өглөө.	
	100%-19, 70%-2, 40%-2			<b>92.1%</b>		

**Төлөвлөгөөг үнэлсэн:**

.....  
(албан тушаал)

Тэмдэг

**Төсвийн шууд захираач**

..... / .....  
(гарын үсэг) (огноо)

**Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:**

.....  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

**Нэгжийн дарга**

..... / .....  
(огноо)

**Тайлagnасан:**

.....  
(албан тушаал)  
.....

**Нэгжийн дарга**

..... / .....  
(гарын үсэг)  
(огноо)